



INSPIRE

Rotary  PEOPLE OF ACTION


2020-2021 Ротарийн Жилийн 3-р улиралын цахим сонин

Rotary 
Clubs of Mongolia


 Rotary Opens
Opportunities

Rotaract 

Interact 



Ротарактуудын гайхалтай манлайллын чадавхыг хамгийн сайн мэддэг хүний хувьд, миний бие 3-р сарын 8-ны өдрөөс 14-ний өдрүүдэд тэмдэглэж байгаа Дэлхийн Ротарактын Долоо хоногт маш их хүлээлттэй байдаг. Ротарактууд бол энэ жилийн миний Ерөнхийлөгчийн хуралдаануудын гол 3 чиглэлийн нэг бөгөөд 2 жилийн өмнө Хуулийн Зөвлөлөөс Ротаракт клубуудыг Олон улсын Ротаригийн гишүүн болгоход санал өгсөнд би маш их бахархаж байлаа. Үүний өмнө Хуулийн Зөвлөл хос гишүүнчлэлийг боломжтой болгосон байсан ба дараахан нь Захирлуудын Зөвлөлөөс Ротарактуудын насны хязгааргүй болгох шийдвэр гаргасан юм. Надад Ротаракт клуб болон Ротари клуб хоорондоо огт ялгаагүй санагддаг. Магадгүй гишүүнчлэлийн дундаж нас л ялгаатай байх. Олон Ротаричууд Ротарактуудыг манай залуучуудын байгууллага гэж хардаг ч миний хувьд өөрөөр хардаг. Миний хувьд бид бол бидний нэг хэсэг, тэд нар бидэн шиг. Хамтдаа амжилттай байхын тулд бид бие биенээ эрх тэгш гэж үзэж харилцан хүндлэх хэрэгтэй. Бүгдээрээ Ротарактуудыгаа оюутан, залуу удирдагч, мөн 2014 оны Берлинд 5 хэлээр хэлэлцүүлэг өөрнүүлсэн шиг нь Ротари байгууллагыг төлөвлөж, удирдаж, зохион байгуулах чадвартай амжилттай менежерүүд, энтрепренерүүд гэдгээр нь харцгаая. Хамтдаа энэхүү аялалд гарахдаа Ротари болон Ротарактын хүч чадлыг санацгаая. Ирээдүйг хамтдаа бүтэлцэх ажлаа шууд эхэлье. Ингэснээр бид байгууллагадаа төгсөшгүй боломжуудыг нээж байгаа билээ.



Эрик Чак
Олон Улсын Ротарийн 3450 Дүүргийн Захирагч



Сайн байцгаана уу

Эрхэм хүндэт үе үеийн Бүсийн захирагч, Бүсийн удирдлага, Клубуудийн Ерөнхийлөгчид болон Ротари гэр бүлийн гишүүдээ, 2020-21 оны Ротари жил бүхэлдээ олон сорилтууд болон боломжууд дунд өнгөрч байна.

Сорилт бүхэн арга зам, боломжуудыг шинээр бий болгож байна. Өнгөрсөн хугацаанд маш олон уулзалт, сургалтууд цахим хэлбэрт шилжиж, дэвшилтэт технологийн болон шинэлэг санаануудыг туршиж, хэрэгжүүлж ирлээ. Бид зайнаас марафон гүйлтэд оролцож, цахимаар концерт, тоглолт үзэн, хандив илгээж, тогтмол олон төрлийн платформ ашиглан хурал, хэлэлцүүлэгт оролцож илүү ойр байж, нэгдэж чадаж байна.

Энэ хугацаанд бид Интеракт клубуудийн үйл ажиллагааг шинэ түвшинд авчран, олон улсын хуралд оролцуулан, нэгдсэн сургалт зохион байгуулж, Ротарийн гэр бүл хэдэн зуун шинэ суратгчаар эгнээгээ тэлсэн байна. Шинээр бий болж буй Интеракт клубуудийг спонсорлох, Ротарийн зарчим, хандлагаар зөв чиглүүлэх, ментор болох Ротари клубуудийг өөрсдийн оролцоог идэвхитэй байлгаж, дэмжиж ажиллахыг уриалж байна.

"Бяцхан баатрууд" хамтарсан төслөө амжилттай хэрэгжүүлсэн нийт Ротаракууд маань олон арван төслүүдийг тогтвортой үргэлжжүүлж, үлгэр жишээ манлайллыг үзүүлсээр байна. Нийт залуучуудаа "To serve, to learn, to lead" уриаг тэнцвэртэйгээр баримтлан, үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг хүсч байна.

Сүүлийн жилүүдэд Олон улсын Ротарийн голлон анхаарч байгаа залуучуудад чиглэсэн бодлогын өөрчлөлт болон хамтын ажиллагааг шинэ түвшинд гаргахын төлөө хамтдаа хичээцгээе.

Энэ жил бид дахин нэг Ротаракт манлайлагч нараас гишүүнчлэлдсэ бүрдүүлсэн "Гэрэгэ" Ротари клубийг амжилттай чартер хийлээ. Үүсгэн байгуулагдсан цагаасаа олон төслүүдэд оролцож, Герман улсын ЭСЯ-тай хамтран шинэ төсөл эхлүүлсэн

Залуучууддаа амжилт хүсье. Төв болон Сэлэнгэ Ротари клубуудэд цахимаар сургалт, уулзалт зохион байгуулсан нь гишүүдийн мэдлэгийг тэлж, урам өгч, идэвхижүүлсэн, орон нутгийн Ротари клубуудийг бэхжүүлсэн үр дүнтэй сургалт болж өнгөрлөө. Цахим эвэб хуудсаар үр өгөөжтэй, суурь мэдлэгүүдийг олж авах платформ бол e-learning center бөгөөд Ротарийн гишүүн болохын хувьд өөртөө зориулж цаг гарган судалж, эхний түвшний сургалтуудыг энэ Ротари жилдээ суралцаж дуусгахыг Монголын нийт клубууддээ дахин уриалж байна.

Ротарийн гишүүн болох нэг хэрэг, харин Ротариан болохын тулд өөрөө өөрийгөө олж, тодорхойлж, бусдад чин сэтгэлээсээ туслах боломжуудыг эрэлхийлж, өөрийн санаачлагаар оролцоог бий болгон, Ротари санд хандивлан, төсөл хөтөлбөрт дэмжлэг үзүүлж идэвхитэй байж, манлайлах зайлшгүй шаардлагатай. Та бүгдийн Ротарийн манлайлалд амжилт хүсье! Ротари боломжийг бий болгоно.

Хүндэтгэсэн,
9 дүгээр бүсийн захирагч **Л.Бат-Эрдэнэ**
10 дугаар бүсийн захирагч **Д.Дамдиндорж**



Ротаричууд-Бүтээгч Хүмүүс

МОНГОЛЫН РОТАРИЧУУД ЭХ ДЭЛХИЙН ӨДРИЙГ ТЭМДЭГЛЭВ.



3450 Ротари дүүргийн 9,10-р бүсэд одоогоор нийт Монголын 16 Ротари клубээс 4 клуб хараахан Green Club-Ногоон клуб болж амжаагүй байгаа бөгөөд 2021/04/30-с өмнө бүртгэлээ хийлгэн Ногоон клуб болох боломжтой ба Green Rotary Club Recognition 2020-2021 буюу Ногоон Ротари клубын батламж гардан авах нөхцөл бүрдэх юм.

Илүү мэдээллийг:
<https://www.rotary.org/en/supporting-environment-becomes-new-area-focus>

МОНГОЛЫН РОТАРИЧУУД ЭХ ДЭЛХИЙН ӨДРИЙГ ТЭМДЭГЛЭВ.

Түүхийн хуудсыг сөхвөл:
АНУ-ын парламентийн гишүүн Гэйлорд Антон Нелсон, Харвардын ИС-ын оюутан Дэнис Хэсийн хамтаар 1969 оны 1 сарын 28-нд Калифорниагийн Санта Барбарад болсон газрын тосны ослоос үүдсэн орчны бохирдолд олон түмний анхаарлыг татах үүднээс 1970 оны 4 сарын 22-нд "Эх дэлхийн өдрийн тунхаг" -ийг анх бичиж олон нийтийн анхаарлыг Байгаль, Эх дэлхийд хандуулснаар 4 сарын 22-ны өдрийг "Эх дэлхийн өдөр" болгон тэмдэглэх болжээ. Уг өдрийн хүрээнд Номт Ротари клубын гишүүд Өвөрхангай аймгийн Bookbridge сургалтын төвийн хүүхэд залуустай "Эх дэлхийн өдөр"-ийн тухай байгаль,орчноо хайрлан хамгаалах арга хэмжээний талаар онлайн уулзалт зохион байгуулав.

ОЛОН УЛСЫН РОТАРИЙН 3450 ДҮҮРГИЙН 9, 10 БҮСИЙН СОНГОГДОХ ЕРӨНХИЙЛӨГЧИЙН БОЛОН БҮСИЙН УДИРДЛАГЫН ЦАХИМ СУРГАЛТ БОЛЛОО

PETS – 4 сарын 17 (Бүс 9, 10)

Хэн Оролцсон:
• Сонгогдох Ерөнхийлөгчид буюу 21-22 оны Ротари жилийн Ерөнхийлөгчид (Ротари клубууд 17 + Ротаракт клубууд 15)
• Дүүргийн Хороодын Дэд Даргууд
Нийт Оролцогчид: 65 Ротаричууд + Дүүргийн Захирагчид асан + Илтгэгчид

DTTS – 4 сарын 18 (Бүс 9,10)

Хэн Оролцсон: Дүүргийн Хороодын Дэд Даргууд
Нийт Оролцогчид: 26 +Дүүргийн Захирагчид Асан + Илтгэгчид

DTA – 4 сарын 18 (Бүс 9,10)


Хэн Оролцсон:
• Сонгогдох Ерөнхийлөгчид Буюу 21-22 Оны Ротари Жилийн Ерөнхийлөгчид
• Клубын Хороодын Дарга Нар Болон Гишүүд
• Бүсийн Удирдлага
Нийт Оролцогчид: 181 Rotarians +Дүүргийн Захирагчид Асан + Илтгэгчид

DTA BEAKOUT – 4 сарын 18 (Бүс 9, 10)

180 гаруй Ротаричууд 6 Группд хуваагдан оролцсон:
• GROUP 1 (Youth/**Залуучууд**) – 30 гишүүд
• GROUP 2 (Foundation /**Сан**) – 26 гишүүд
• GROUP 3 (Membership/**Гишүүнчлэл**) – 28 гишүүд
• GROUP 4 (Public Image/Олон Нийтэд Таниулах) – 26 гишүүд
• GROUP 5 (Project/**Төсөл**) – 32 гишүүд
• GROUP 6 (Preserve Planet Environment/**Байгалаа хамгаалах**) - 30 гишүүд



2021 оны 4 сарын 18-нд зохион байгуулагдсан DTA Break Out session дээр Монголын 20-30 орчим Ротариан болон Ротаричууд Preserve Planet Earth Committee-Эх дэлхийгээ хайрлах хорооны талаар мэдээлэл, чиг үүргийн талаар ойлголтыг олж авлаа.





РОТАРИ 3450 ДҮҮРГИЙН ЦАХИМ ХАНДИВИЙН ТОГЛОЛТООР 350,000 ХК ДОЛЛАРЫН ХАНДИВ ЦУГЛАРЧЭЭ.

2021 оны 3 сарын 27нд 30 гаруй Ротаричууд Ротари 3450 дүүрэг, Kingspark Hong Kong болон Kai Tak Ротари клубуудтай хамтран зохион байгуулсан 3 цагийн Цахим Тоглолтнд оролцож St. James' Settlement People's Food Bank (Hong Kong) байгуулагад туслах хандивийн тоглолт байсан. Энэхүү байгууллага нь энэхүү хүнд цаг үеэр хүний анхдагч хэрэгцээ хоол, хүсний дутагдалт орсон хүмүүст тусалдаг. Анхны Цахим Хандивийн Тоглолтонд Монголын Ротари клубууд өөрийн дуулсан бичлэгүүдээрээ оролцон юм. Мөн алдарт дуучин Patrick Dunn 4 дуу дуулж өөрийн хувь нэмрээ оруулсан юм. Нийт 350,000 ХК долларын хандив цуглуулж 4 сарын 13нд энэхүү хандиваа St. James' Settlement байгууллагын захирал Ms. Josephine Lee-д гардуулсан билээ.

Цахим тоглолтын бүтэн бичлэгийг дараах Youtube холбоосоор үзээрэй: <https://youtu.be/w7p7o-ucn3Y>



2020-2021 ОНЫ РОА ЗУРГИЙН УРАЛДААН

Зорилго:

1. Төсөл, энх тайваныг дэмжих болон манлайлалыг хөгжүүлэх гэх зэрэг Үйл Явцыг харуулсан Зурагнуудаар /Action Photos/ дамжуулан Ротарийн Олон нийтийн дүр төрхийг сурталчилах;
2. Ротарийн түүхүүдийг Үйл Явцыг харуулсан Зурагнууд /Action Photos/-аар дамжуулан түгээх;

РоА /Зургийн уралдааны/ Facebook хуудас:

2020-2021 Rotary PoA Photo Competition

Шагнал урамшуулал:

Нийт 4 үе явагдана

Үе тус бүрээс 15 зургийг хамгийн их Like болон шүүгч нарын саналаар шалгаруулна

4 үе-ийн дараа 60 зурганаас ялагч нар болон тусгай шагнал бүхий РоА зургийн уралдааны үр дүнг 2021 оны 5 сарын 22-нд болох 61-р Дүүргийн Конференцийн үеэр танилцуулагдах болно.

Ялагч клуб нь мөнгөн шагнал авах ба шагналын мөнгө нь 2020-2021 оны төсөлд зарцуулагдах ёстой.

РоА зургийн уралдааны шагналууд:

Ялагч, Аврагын цомын эзэн клуб – 10,000HKD

1-р байр – 5,000 HKD

2-р байр – 3,000 HKD

3-р байр – 2,000 HKD

4-р байр – 1,000 HKD

Тусгай шагналууд:


“Go Green” зургийн шагнал: Шилдэг 3 зураг тус бүрт 1,000 HKD

“Better Health” зургийн шагнал: Шилдэг 3 зураг тус бүрт 1,000 HKD

“Young Power” зургийн шагнал: Шилдэг 3 зураг тус бүрт 1,000 HKD



НИЙТ ШАЛГАРСАН ЗУРАГНУУД



ХҮРЭЭ РОТАРИ КЛУБ

2020-2021 оны Ерөнхийлөгч Б.Бадамсүрэн

“ИНТЕРАКТ БА МИНИЙ БОЛОМЖ” ЗОХИОН БИЧЛЭГИЙН УРАЛДААН

Хүрээ Ротари клуб Интерактудын дунд “Интеракт ба миний боломж” сэдвээр зохион бичлэгийн уралдаан зарлаж нийт 2 Интеракт клубын хүүхдүүд оролцсон. Шилдэг зохион бичлэгийг Хүрээ Ротари клубын Ерөнхийлөгч, Дэд Ерөнхийлөгч, Нарийн бичгийн дарга нар шалгаруулсан ба шагнал нь сонинд нийтлэх болон Хүрээ Ротари клубын 20 жилийн ойн сэтгүүлд гаргах.

Номын сангийн төсөл

Номын сангийн төсөл GG 1989607 Нийт 43000 \$-ын өртөгтэй. Номын сангийн төсөл нь захын хороололын хуучинаараа байгаа номын санг шинэчилж, номын баазыг нэмэгдүүлэх зорилготой. Энэ удаа Нийслэлийн Сүхбаатар дүүрэг, Чингэлтэй дүүргийн 35, 39, 72, 138 -р сургуулиудыг сонгож авсан. Эдгээр сургуулиудын номын сангийн бүрэн засвар, тавилгуудыг бүрэн шинэчлэн, хэрэгцээтэй номнуудаас гадна орчин үеийн хүүхэд залуучуудын нэвтэрхий толь зэргээр номын баазыг нь баяжуулж өгсөн байгаа.



СЭЛЭНГЭ РОТАРИ КЛУБ

2020-2021 оны Ерөнхийлөгч Б.Цээпилдорж

КОВИДЫН ЭСРЭГ РОТАРИЧУУД НЭГДЭЖ БАЙНА

Дэлхий нийтэд тархаад буй Ковид-19 цар тахлаас шалтгаалан 2021 онд хийж хэрэгжүүлэх ажил арга хэмжээнүүд хойшлогдож, цуцлагдаж, клубын гишүүдийн уулзалт хурлууд цахим хэлбэрээр зохион байгуулагдахад хүрлээ.

2021 оны ажлын жил Сэлэнгэ ротари клубын ерөнхийлөгч Б.Цээпилдорж, нарийн бичиг Ж.Энхмаа нар ажиллаж цаг үеийн амаргүй нөхцөл байдалд клубын гишүүдэд идэвхжүүлэх, урам зоригоор урамшуулах, Дүүрэг, Бүстэйгээ нягт хамтран ажиллахад анхаарал хандуулан ажиллалаа.

Монгол улсын гадаад худалдааны үүд хаалга болсон Сэлэнгэ аймагт маань 2020 оны 11 дүгээр сард Ковид-19-ийн анхны тохиолдол

бүртгэгдэж, 11 дүгээр сарын 11-ний өдрөөс бүх нийтийн өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжиж хүндхэн нөхцөл байдалтай тулгарав. Цаг үеийн хүнд үед Дүүрэг, Бүсийн захиргаа, бусад клубууд хамтран хандив тусламжийн аяныг шуурхай зохион байгуулж хамгийн эхний хандивыг манай клубт гардуулан өгөв.

Монголын Ротаричуудаас ирүүлсэн энэхүү хандивыг Сэлэнгэ Ротари клубын гишүүд өөрсдийн 3.4 сая төгрөгийн хандивын хамт аймгийн Онцгой комисст хүлээлгэн өглөө.



3450 ДҮҮРГИЙН 9, 10 БҮСИЙН ЗАХИРАГЧ НАРЫН ЦАХИМ АЙЧЛАЛ

2021 оны 03 дугаар сарын 16-ны өдөр Ротарийн 9, 10 дугаар бүсийн Захирагч нартай Сэлэнгэ клубын гишүүдтэй цахим уулзалтыг зохион байгууллаа. Уулзалтаар цаг үеийн тодорхой сургалт, уулзалтууд болон бусад асуудлын талаар дэлгэрэнгүй ярилцан санал солилцлоо.



ЯВГАН АЙЛАЛЛААР ДҮҮРГИЙН УЛТРАМАРАТОНД ОРОЛЦОВ.

3 сарын 21-ний өдөр Сэлэнгэ клубын гишүүд 3450 Дүүргийн Ултрамаратонд Монголын Ротаричуудаа төлөөлөн аймгийн төв Сүхбаатар суманд явган аялалыг зохион байгуулж 11.8 км-ийн алхалт хийсэн.



ЗУУНМОД РОТАРИ КЛУБ

2020-2021 оны Ерөнхийлөгч Д.Мияажав

2021-1 САР “ЗУУНМОД – ЗУУН ХҮҮХЭД”

Орон нутгийнхаа амьдралын боломж хүнд айл өрхийн хүүхдүүдийг өвлийн дулаан хувцасаар хангах төслийн 2-р үе шат амжилттай хэрэгжиж дууслаа

Нийт 102 хүүхдэд өвлийн улирлыг өнтэй давахад нь туслалцаа үзүүлж дулаан малгай, ороолт, өвлийн гутал гадуур хувцас зэрэг 150 гаруй нэр төрлийн 6000 сая төгрөгийн үнийн дүнтэй төсөл болж хэрэгжлээ.

Энэхүү төсөлд Бүс, Ротари клубууд болон хувь хүмүүс байгууллагын хандиваар нийт 4,200,0 төгрөгний хандив цугларсан ба бяцхан хүүхдүүдэд тусламжийн гараа сунган мөнгөн болон эд материалын хандив өргөсөн хүн бүхэнд баярлалаа.

2021- 2 САР РОТАРИ ӨДӨР

Жил бүрийн 1-р сарын 23 ны өдөр Ротаричууд үүсэн байгуулагдсан түүхэн өдрөө өөр өөрсдийн улс оронд эв санаа, нөхөрлөл, сайн үйлсийн төлөө үйл ажиллагаа, үзэл санаагаа нэгтгэн баяртайгаар тэмдэглэн өнгөрүүлдэг билээ.

2021.03 #ROTARYRESPONDSCOVID-19



Энэ оны 3-р сараас Зуунмод хотын хэмжээнд Ковид19 цар тахал шинээр голомтлон гарч өвчний тархалт хурдтай нэмэгдсэн, хатуу хөл хориотой байх үед Аймаг, сумын Онцгой байдлын газраас хамтран ажиллахыг хүсэж хүсэлтээ ирүүлсэний дагуу Зуунмод Ротари клуб нэн шаардлагатай байгаа хамгаалах хэрэгсэл хувцас, гар ариутгагч, маск, бээлий, автомат ариутгагч төхөөрөмж зэрэг 2500\$ өртөг бүхий тусламжийг хэрэгцээт байгууллага хамт олонд нь хүлээлгэн өглөө. Тусламжийн үйл ажиллагааг дэмжин шуурхай хамтран ажилласан Бүсийн Захирагч Дамдиндорж, Бат-эрдэнэ болон багийн гишүүдэд нийт клубынхээ гишүүдийн өмнөөс талархал илэрхийлье

Зуунмод Ротари клуб Ротарийн 116 дахь өдрөөр клубын хүндэтгэлийн цуглаан зохион байгуулж өнгөрсөн хугацаанд манлайлан ажилласан гишүүн Ротаричуудаа алдаршуулан Клубын Аасемблү зохион байгууллаа.

2021-04 PETS/DTTS

Жил бүр давтамжтайгаар зохион байгуулагддаг Ротарийн бизнесийн шинэ жилд гишүүд удирдагчдаа бэлтгэдэг уламжлалт Сонгогдох албан тушаалтан, Ерөнхийлөгчдийн нэгдсэн сургалтуудад Зуунмод Ротари клуб Удирдах Зөвлөл болон Хороодын дарга нар нийт 5 гишүүн оролцож шинэ Ротарийн жилд баримтлах журам, өөрчлөлт, шинэлэг уриа зорилтуудтай танилцан шинэ мэдлэг шинэ эрч хүч авлаа.



СЭЛБЭ РОТАРИ КЛУБ

2020-2021 оны Ерөнхийлөгч О.Батгэрэл

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРТ ГЛОБАЛ ГРАНТ

Сэлбэ Ротари клуб Японы Хирошима Минами (Hiroshima South RC; RID2710) клубтэй хамтарсан Глобал Грант (ID: GG 2119832) 2021 оны 3 сард батлагдан, үйл ажиллагаагаа хэрэгжүүлж эхлээд байна.


Сэдэв : Training of Mongolian medical doctors for early diagnosis on respiratory diseases in Mongolia

Монгол улсын хүн амын дунд амьсгалын замын өвчлөл өндөр байдаг ч орчин үеийн оношилгоо эмчилгээний асуудал хангалттай шийдэгдээгүй хэвээр байна. Үүний нэг шалтгаан нь амьсгалын замын өвчнийг эрт оношлоход ач холбогдолтой шинжилгээний арга болох уушигны дурангийн шинжилгээ бүрэн нэвтрээгүй, энэ чиглэлийн шинжилгээний арга техник эзэмшсэн эмч мэргэжилтэн цөөхөн байгаа явдал юм. Тиймээс энэхүү төслийн зорилго нь эдгээр шинжилгээг зохих ёсоор гүйцэтгэж чадах эмч мэргэжилтнүүдийг VTT хэлбэрээр Япон улсын их дээд сургуулийн эмнэлэгт сургаж, оношилгоо эмчлгээний чадавхийг нэмэгдүүлэхийн тулд хамгийн сүүлийн үеийн цээжний хөндийн дурангийн аппарат (Бронхоскопи) төхөөрөмж хандивлах юм. Төслийн эцсийн үр шимийг хүртэгчид нь амьсгалын замын өвчнөөр шаналж буй Монгол дахь уурхай, үйлдвэрийн ажилчид болон нийслэл Улаанбаатар хотын оршин суугч нийт хүн ам юм.

Төслийн нийт өртөг 38500 америк доллар

ONLINE ACADEMY-Д БҮХ ШАТНЫ СУРГАЛТЫГ АМЖИЛТТАЙ ДҮҮРГЭЛЭЭ

Сэлбэ клубын ерөнхийлөгч О.Батгэрэл ONLINE ACADEMY дахь цахим сургалтын нийт 104 хөтөлбөрт бүрэн хамрагдаж, Ротарийн талаарх мэдлэгээ өргөжүүллээ. Нийт 47 badge, 1241 point (одоогоор 3450 дүүргийн хамгийн өндөр оноо) оноо цуглуулж бүх 4 шатны сургалтыг суралцаж дуусгасан.




РОТАРИ ГИШҮҮНЧЛЭЛ: 20-21 РОТАРИ ЖИЛИЙН МОНГОЛЫН РОТАРИ КЛУБУУДЫН ГИШҮҮНЧЛЭЛИЙН ӨСӨЛТ 6,6% БАЙНА.

Ковид 19 дэлхий даяр тархаж байгаа энэ хүнд хэцүү нөхцөлийг үл харгалзан манай 3450 дүүргийн нийт гишүүдийн тоо тогтвортой өссөөр байгаа бөгөөд 2021 оны 3 дугаар сарын байдлаар нийт 2649 гишүүнтэй болсноос, шинээр 83 гишүүн бүртгэгдсэн нь гишүүнчлэлийн өсөлт 3,2 %-тай байгааг илэрхийлж байна. /дэлхийн түвшинд 1.4%-ийн өсөлт/ Манай Монголын Ротари клубууд гишүүнчлэлээ бэхжүүлэх тал

дээр цуцалтгүй хүчин чармайлалт гаргаж, энэ жилдээ багтаан шинэ гишүүд эгнээндээ элсүүлж, аль болохоор гишүүдээ алдахгүй тал дээр онцгой анхаарал тавьж ажилласны үр дүнд 2021 оны 4 сарын байдлаар 373 гишүүнтэй болж чадсан нь гишүүнчлэлийн цэвэр өсөлт 23 шинэ гишүүнээр буюу 6.6%-тай байгааг харуулж байна.

2014-2020 ОНУУДЫН ГИШҮҮНЧЛЭЛИЙН ӨСӨЛТ

Ротарийн жил	2014-2015	2015-2016	2016-2017	2017-2018	2018-2019	2019-2020	2020-2021
Нийт гишүүдийн тоо	261	289	320	318	352	350	373
Гишүүнчлэлийн өсөлтийн хувь		10.70%	10.70%	-1%	11%	-0.53%	6.6%



Энэ жилийн Ротарийн жил дуусахад 2 сар орчим үлдсэн тул Та бүгдэд гишүүнчлэлийн ажлаа улам их идэвхжүүлэхэд Бүсийн гишүүнчлэлийн хорооноос дараахь зүйлүүдийг анхаарахыг зөвлөж байна:

- Гишүүнчлэлийн бодлогыг өөрийн клубийн №1 болгон хэрэгжүүлэх, учир нь гишүүдтэй байж л клуб оршино тогтоно. Идэвхтэй олон гишүүдтэй байснаар клубууд маань хүчирхэг байж, илүү чадавхитай болно.
- Клубийнхээ хурлуудыг биет хэлбэрээр хийх боломжгүй тохиолдолд цахим болон холимог хэлбэрээр тогтмол хийж, цар тахлын үед чидэвхээ сулруулахгүй байж, шинэ болмжуудыг нээх

/Бүсийн захирагч нартай үнэ төлбөргүй Zoom хэрэглэх талаар холбогдоорой/

- Шинэ гишүүдийг өөрийн хувийн болон ажил албаны хүрээндээ тодруулж, клубээ танилцуулсан арга хэмжээнд урих
- Шинэ гишүүдээ элсүүлэх ёслолдоо онцгойлон анхаарч, шинэ гишүүдээ клубийн үйл ажиллагаандаа элссэн өдрөөс нь эхлэн хамруулж, туршлагтай Ротаричуудаа ментор болгох
- Гишүүн болгон My Rotary-д бүртгүүлж, Ротарийн талаарх ерөнхий мэдлэгээ цахим сургалтанд хамрагдан дээшлүүлж, бусдад Ротарийн талаар мэдээлэл өгөх чадвартай болох
- Өөрийн клубийн давуу талуудыг клубээрээ дүгнэн тодорхойлж, сонирхсон хүмүүсд клубээ илүү сайн сурталчилж, улмаар гишүүн болох сонирхолыг нь бататгах
- Бид хамтын зүтгэлээрээ нийгэмдээ ямар эерэг өөрчлөлт гаргаж байгаа талаар мөн ямар гайхамшигтай төслүүд хэрэгжүүлсэн түүхүүдийг бусдад ярьж, шинэ гишүүдийн

- сонирхолыг татах
 - Олон нийтийн сүлжээнд клубийнхээ үйл ажиллагааг идэвхтэй сурталчилах
- Дүүргийн ба бүсийн гишүүнчлэлийн хорооны зүгээс урамшуулалуудыг зарласан байгаа, үүнд:
- Дүүргийн зүгээс 2021 оны 7-р сарын 21-ээс хойш гишүүнчлэлийн цэвэр өсөлт гаргасан гишүүдийн тоо болгонд тус бүр 1000 HK\$
 - Бүсийн гишүүнчлэлийн хорооны зүгээс 9,10-р бүсүүдийн 2 клубд тус бүрт 100,000\$-ний шагнал
- Шинэ гишүүдэд болон тэднийг элсүүлсэн Ротаричуудад тусгай тэмдэг гардуулах болно.



НОМТ РОТАРИ КЛУБ

2020-2021 оны Ерөнхийлөгч Ц.Оюунчимэг



“ХАЙРААР ДҮҮРЭН БОГЦ” АЯН

"Хайраар дүүрэн богц" аяны хүрээнд Номт Ротари клубын хамт олон төв аймгийн тусламж, дэмжлэг шаардлагатай, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй, өрх толгойлсон эцэг, эх, зорилтот зэрэг 10 өрхүүдэд 250,000 төгрөг хандивлахаар 11 нэр төрлийн бараа бүтээгдэхүүн худалдан авч хүргэж өглөө.



"1 ЖИЛД 1 ХҮҮХДЭД 1 САВАН" ХАНДИВЫН АЯН

"1 жилд 1 хүүхдэд 1 саван" хандивын аяныг дэмжин, хүүхдүүдийг сургууль дээрээ гараа угаах боломжийг бүрдүүлэхэд хувь нэмрээ оруулсан нийт 200.000 төгрөг хандивласан бөгөөд 1 хүүхдэд 1 саван зарцуулахад тухайн сургууль бүтэн хичээлийн жилийн турш гар угаах савангаар бүрэн хангагдах боломжтой юм.

#КовидынЭсрэгХамтдаа #1child1soap #1хүүхдэд1саван #савангийнхандив #ЭрүүлАхуйнАян2020 #HygieneCampaign2020



РОТАРИ САН: 3450 ДҮҮРЭГ ЖИЛ 722,818 АМ ДОЛЛАРЫН ХАНДИВ РОТАРИ САНД ӨРГӨЖЭЭ.

2020-21 Ротари жилийн эхний хагаст 3450 дүүргийн 9, 10-р бүсийн клубүүд даян дэлхийн сайн сайхны төлөөх Ротари сангаа үргэлж дэмжиж хамтран ажилладагт баярлалаа.

Ротари Сангийн эрхэм зорилго нь Ротарийн гишүүдээр дамжуулан эрүүл мэндийг сайжруулах, боловсролыг дэмжих, ядуурлыг бууруулах замаар дэлхийд сайн санааны болон энх тайвныг хөгжүүлэх боломжийг олгодог. Бид бүхний энэ жил өргөсөн нийт хандив нь 3 жилийн дараах Грантад зориулагдан манай дүүрэгт хуваарилагддаг ба 3450 дүүрэг маань энэ жил 722,818 ам долларын хандивыг тус санл өргөжээ 7-р сарын 1 хүртэл энэ дүн дахин нэмэгдэнэ хэмээн найдаж байна.

Ротари санд гишүүн бүр жил бүр 100 ам доллараас дээш хандив өргөхийг уриалдаг ба энэ жил дараах 7 клубийн гишүүд дунджаар 100 ам доллараас дээш хандивыг өргөж 100% EREY клуб болжээ;

Та бүхнийг цаашид ч бусдын төлөөх үйлсэд гар бие оролцон төсөл хөтөлбөр хэрэгжүүлэхийн сацуу Ротари сандаа хандив өргөж дэмжихийг уриалж байна. Мөн Глобал Грант, Дүүргийн Грант хөтөлбөрүүдэд идэвхитэй хамрагдаж орон нутгийн болон олон улсын төслүүдэд хувь нэмрээ оруулна хэмээн найдаж байна.

ОУ Ротари 3450 дүүргийн Ротари Сангийн хорооны дэд дарга, РАГ Б. Булган

100% EREY КЛУБУУД:

- УЛААНБААТАР
- ХҮРЭЭ
- СЭЛБЭ
- НАРЛАГ УЛААНБААТАР
- УЛААНБААТАР ПИЙС АВЕНЬЮ
- УЛААНБААТАР ХАНГАРЬД
- УЛААНБААТАР ЦЕНТРАЛ



УЛААНБААТАР ЦЕНТРАЛ РОТАРИ КЛУБ

2020-2021 оны Ерөнхийлөгч Г. Ундрам

"ЗАНГИАГҮЙ ЦАХИМ УУЛЗАЛТ" Vol.1 2020.01.06

Бид шинэ оны эхэнд онлайнаар уулзалтаа хийж байх зөвлөмжийн дагуу "ЗАНГИАГҮЙ ЦАХИМ УУЛЗАЛТ" -ыг санаачлан хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд анхны зочноор 10-р бүсийн захирагч Д.Дамдиндорж оролцлоо. Тэрээр Ротари байгууллагатай хэрхэн холбогдож байсан, ямар төслүүд санаачлан хэрэгжүүлсэн тухай олон сайхан дурсамжуудаасаа хуваалцсан юм. Мөн уулзалтад Гэрэгэ Ротари клуб, Улаанбаатар Централ Ротаракт клубийнхэн оролцлоо.



"ЗАНГИАГҮЙ ЦАХИМ УУЛЗАЛТ" Vol 2 БУЮУ ӨӨРИЙГӨӨ ХОВСДОЖ СТРЕССЭЭС АНГИЖРАХҮЙ 2020.02.18

Ковид-19 цар тахалтай холбоотойгоор нийгэм стресс бухимдлаар дүүрч байгаа энэ үед өөрийгөө хэрхэн стрессээс ангижруулах тухай сонирхолтой сэдвээр гишүүн Ц.Мөнх-Эрдэнэ яриа өрнүүлээ. Бид гишүүдийнхээ мэргэжлийг сурталчлах бусадтайгаа мэдлэг мэдээллээ хуваалцах олон ажил хийдгийн нэг нь энэхүү уулзалт байлаа.

ТӨСЛИЙН ОРОЛЦОГЧИДДОО КОВИД-19 ЦАР ТАХЛААС СЭРГИЙЛЭХ ВАКЦИНЫ ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ ӨГЛӨӨ 2020.03.26

Чингэлтэй дүүргийн 10-р хороонд байрлах "Амьдралын төлөөх гэр" төслийн оролцогчиддоо Ковид-19 цар тахлын эсрэг вакцины талаарх мэргэжлийн байгууллагаас өгч байгаа зөвлөмж, мэдээллийг хүргэж вакцинд хамрагдахыг уриаллаа. Мөн энэ үеэр бэлгийн замын халдварт өвчин, сүрьеэ өвчнөөс хэрхэн сэргийлэх талаар нэгдсэн сургалтыг орсон юм. Сургалтыг Чингэлтэй дүүргийн Улаан загалмай, дүүргийн өрхийн эмнэлэгтэй хамтран хийлээ.




"АМЬДРАЛЫН ТӨЛӨӨХ ГЭР" ТӨСЛИЙН МЭРГЭШИЛ ОЛГОХ СУРГАЛТУУД ЭХЛЭХЭД БЭЛЭН БОЛЛОО 2020.04.02

Энэ жил бид "АМЬДРАЛЫН ТӨЛӨӨХ ГЭР" төсөлдөө Global Grant-ын болзол хангаж, санхүүжилтаа авсан билээ. Энэ хүрээнд төслийн сургалтын гэрйг иж бүрэн таван компьютер, дэлгэц гэх мэт сургалтын хэрэглэгдэхүүний худалдан авалт хийгдээд байна. Төслийн оролцогчид компьютерийн анхан шатны хэрэглээ, амьдрах ухаан, хандлагын сургалтууд болон хоол үйлдвэрлэл, талх нарийн боов, оёдол эсгүүр, нэхмэл, маникюр, гар урлал, үсчин, бариста, цахилгаанчин, гагнуурчин гэх мэт арав гаруй мэргэшлийн сургалтаас сонгон суралцаж чадамжийн гэрчилгээгээ авах юм.



The Rotary Foundation (TRF) Money Flow



НАРЛАГ УЛААНБААТАР РОТАРИ КЛУБ

2020-2021 оны Ерөнхийлөгч Н.Эрдэнэбаяр

Манай клуб үйл ажиллагаагаа албан ёсоор эхлүүлээд 8 дах жилээ дурсамж дүүрэн өнгөрүүлж байна. Бид сар бүр 3 удаа клубын хурлаа биеэр болон онлайнаар тогтмол хийж цаг үеийн мэдээ мэдээлэлээ солилцохоос гадна 1 удаа чөлөөт арга хэмжээг зохион явуулж ирлээ. Түүнчлэн энэ жилийн онцгойлон анхаарлаа хандуулан ажилласан зүйлсийн нэг болох клубын гишүүнчлэлээ өргөжүүлэх зорилтоо хангахаар олон шинэлэг ажлыг зохион байгуулж нийт 6 шинэ гишүүнээр ам бүл нэмлээ.



“ХИЧЭЭЛДЭЭ БЭЛТГЭЕ I, II” БОЛОН “REDRONE” ТӨСЛҮҮД

Хэдийгээр 2020-2021 оны Ротари жил дэлхий нийтийг хамарсан Коронавируст (COVID 19) халдварын цар тахлын хүнд сорилттой тулгарсан ч шинээр сурч мэдсэн, хөгжилд тэмүүлсэн нэгэн он байлаа. Энэ жил бидний хувьд бусад клубүүдээ уриалан дотооддоо хандив босгон хэрэгжүүлсэн “Хичээлдээ бэлтгэе I, II” 2 үе шаттай төсөл болон Тамир, Улаанбаатар Ротари клуб, JCI Capital, ЦССҮТ-тэй хамтарсан Ротаригийн 3450 дүүргийн грантад шалгарсан “REDRone” төслийг амжилттай хэрэгжүүлэн, нийгмийн сайн сайхны төлөө өөрсдийн хувь нэмрээ оруулав.



3 ЖИД ДАРААЛАН 100% EREY КЛУБ ба 3 Paul Harris Fellow-той боллоо.

Сүүлийн 3 жил дараалан клубын гишүүн бүр \$100 Ротари санд хандивлан, 100% Every Rotarian Every Year болзлыг хангаснаас гадна энэ жилийн Ерөнхийлөгч Н.Эрдэнэбаяр, PP X.Онон, IPP X.Уранхайч нар тус тус Paul Harris Fellow шагналыг хүртсэн амжилттай байлаа.

“ШИНЭ ЭХЛЭЛ” ИНТЕРАКТ КЛУБИЙГ ШИНЭЭР ӨЛГИЙДӨН АВЛАА

Ротарийн залуу үеийг хөгжүүлэхэд чиглэн албан ёсоор Youth хороог ажилуулан, өөрийн охин клуб болох “Наран” интеракт клубийн үйл ажиллагааг дэмжихийн сацуу “Шинэ Эхлэл” Интеракт клубийг шинээр өлгийдөн авлаа.

“Шинэ Эхлэл” Интеракт клубдээ Амжилт!

ReDrone ТӨСӨЛ: ЦУС, ЦУСАН БҮТЭЭГДЭХҮҮН АГААРААР ТЭЭВЭРЛЭГДЭЖ ЭХЭЛЛЭЭ

“Нарлаг Улаанбаатар Ротари” клуб Цус сэлбэлт судлалын үндэсний төвтэй хамтарч Нисгэгчгүй нисэх төхөөрөмж (дрон)-ийг ашиглан цус, цусан бүтээгдэхүүнийг тээвэрлэх **“REDrone” (Red drone)** төслийг санаачилсан бөгөөд **“ЦУС ТЭЭВЭРЛЭХ АНХНЫ НИСЛЭГ”**-ийн нээлтийн ажиллагааг амжилттай зохион байгууллаа. Нарлаг Улаанбаатар Ротари клубын 20-21 оны Ерөнхийлөгч, ЦССҮТ-ийн захирал, Намжилын Эрдэнэбаяр: “Би 2018 онд Олон улсын хуралд оролцох үеэрээ “Африкийн Руанда улсад дроноор цус, цусан бүтээгдэхүүнийг тээвэрлэдэг” талаар мэдээлэл авч, улмаар эх орондоо хэрэгжүүлэх санаачилга гаргаж “Нарлаг Улаанбаатар Ротари” клубынханд хандсан нь өнөөдөр ийнхүү бодит биелэлээ оллоо. Энэхүү төсөл хэрэгжсэнээр эмнэлгүүдэд яаралтай үед шаардлагатай цус, цусан бүтээгдэхүүнийг богино хугацаанд хүргэх боломж бүрдсэнээс гадна ердийн хэлбэрээр цус тээвэрлэхэд шаардагддаг хүний нөөц, бензин шатахуун, цаг хугацааг хэмнэх зэрэг эдийн засгийн талаасаа ч үр ашигтай юм. Өөрөөр хэлбэл, олон талын ач холбогдолтой төсөл хэрэгжиж эхэлсэн гэсэн үг.

Санхүүжилтийн тухайд төслийн нийт зардал 11,000 ам.доллар болсон бөгөөд 2020 оны 7 дугаар сард Нарлаг Улаанбаатар Ротари клуб маань Олон улсын Ротари 3450 дүүргээс зарласан төслийн сонгон шалгаруулалтад энэхүү төслийг илгээснээр хэрэгжих боломжтой хамгийн сайн төслөөр шалгарч, анхны санхүүжилтээ авсан юмаа. Түүнчлэн Монгол Улсад үйл ажиллагаа явуулдаг 9,10 дугаар бүс, Улаанбаатар Ротари Клуб, Тамир Ротари клуб болон JCI Капитал салбар байгууллага хамтран ажиллаж, бодит дэмжлэгийг үзүүлсэн байна. Тодруулбал, төсвөөс мөнгө харах биш Олон улсын боломжийг соргоогоор олж харж, сайн төсөл боловсруулах замаар санхүүжилтээ олж авсан. Эрүүл мэндийн салбарт загвар болохуйц энэхүү төслийг санаачлагчид, гардан хэрэгжүүлэгчид болон хамтран дэмжин ажилласан нийт байгууллага, хувь хүмүүстээ Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн хамт олны зүгээс талархал илэрхийлж, ажлын өндөр амжилт хүсье.



УЛААНБААТАР ПИЙС АВЕНЬЮ РОТАРИ КЛУБ

2020-2021 оны Ерөнхийлөгч Д. Гантулга

Улаанбаатар Пийс Авенью Ротари Клуб 2021 цар тахлын хөл хорионы үеэр ч дотоодын болон олон улсын төслүүдээ үргэлжлүүлж байна.

“ХАМТДАА УНШИЦГААЯ-LET’S READ” ТӨСӨЛ

2021 оны 4 дүгээр сарын цахим хуралд “Хамтдаа уншицгаая-Let’s Read” төслийн оролцогч Өмнөговь аймгийн сургуулийн багш нар болон сурагчид болон төсөлд хамтран оролцсон Улаанбаатар Ротари Клубын Ерөнхийлөгч С.Энхтүяа нар оролцон, төслийн үр дүнд сургалт, хүмүүжлийн ажилд ямар дэвшил гарсан тухай, цаашид хэрхэн үргэлжлүүлэх сонирхолтой байгаагаа хуваалцахын сацуу сэтгэгдлээ хуваалцав.



#1LOVE1PACKAGE – НЭГ ХҮН НЭГ ЭМЧИД

Улаанбаатар Пийс Авенью Ротари Клуб нь Ковид-19 цар тахлын эсрэг ачааны хүндийг нуруундаа үүрч, эрсдэлтэй орчинд ажиллаж байгаа эмч сувилагч нараас эерэг тохиолдол ихээр гарч байгаад санаа зовж байна. Цагаан нөмрөгт эмч, сувилагч, асрагч нарынхаа дархлааг дэмжих, мөн нийгэмд зөв үлгэр дуурайл үзүүлэх, олон нийтийг халдварын тархалтын эсрэг зөв арга хэмжээ авч, эрүүл мэнддээ анхаарахыг сурталчилан таниулах зорилгоор #1Love1Package – Нэг Хүн, Нэг Эмчид гэх нэртэй Чалленж төслийг санаачлан хэрэгжүүлэх гэж байна. Энэ жил үүсгэн байгуулж үйл ажиллагаагаа эхэлж байгаа 23-р сургуулийн Интеракт клубын хүүхдүүдтэйгээ хамтран сошил орчинд олон нийтэд таниулах ажлыг мөн давхар хийхээр боллоо.

Rotary Club of Ulaanbaatar Peace Avenue – манай цахим талбарууд:

rotaryclub.mn
facebook.com/RotaryPeaceAvenue/
instagram.com/rcubpa/
twitter.com/rotary_peace


Ковид-19 цар тахалтай тэмцэж байгаа Эмчийн зүрвасаас:

Тийлэж байна гэхдээ бид хэзээ ч иргэдээ (овчлон) орхицгүй! Зүгээр л жаахан урам бидэнд хэрэгтэй байна. Урам хайрла! Тэнхээ ороогч л явчихна. Тусгай хамгаалалтын хувцастай бүтэн 24 цагийн турин агаар амьсгалахгүй шахам ажиллах ямар байдгийг та төсөөлж байсан уу? Ер нь тэднийг оронд өөрсдийгөө нэг тавьж үзсэн үү? Нүүр рүү нь халс нь урсавч арчиж чадахгүй, хүүсэн цагтаа сууж тухалж чадахгүй, өмссөн налперсаа шингэнээр хэвт дүүргэхгүйн тулд ам норгох төдий л ус ундаа ууна. Хоолны талаар бараг ярих ч хэрэггүй. Эмнэлгээс тавьж өгсөн үнэтэй цайтай тусгай өмсөлийг тултал нь ашиглаж байж л хаяхыг хичээнэ. Үнэндээ энэ хувцсыг өмссөн л бол хүндрэх хориотой... Өвдсөн хүмүүсийг үзэх, эмчлэхийн зэрэгцээ заримдаа загнуулж, элдвээр хэлүүлэх ч энүүхэнд. Ээжийнхээ өтгөн шингэнийг зовж үзээгүй мөртлөө хар элгийн хэн нэгний гутлыг өмсүүлж дотуур өмчийг угааж ч үзнэ. Тэртээ харилгүй сар дамжаж, нялах үрстэйгээ утсаар л уулзана. Сайн ханьтай ч яахав, харин хэцүүхэн ханьтай зарим нь нөхөртөө загнуулж, хадлууддаа чиглүүлж амаргүй өдрүүдийг өнгөрөөж яваа. Тийм болохоор эмч сувилагч асрагч найздаа, танилдаа, хамаатан садны хэн нэгэндээ сайхан үг хэлж сэтгэлийн дэм өгөөрэй. Салбар нь хэл ам ихтэй, дарга удирдлагууд нь увайгүй ч эмч, сувилагч, ажилтнуудын буруу гэж юу байхав дээ?



NGSE ТӨСӨЛ

NGSE (New Generation Study Exchange) төслийн цахим уулзалтуудад хамтрагч Олон Улсын Ротаригийн 6690 дүүргийн Америк Ротари клубуудын төлөөлөл, Ротарийн Олон улсын солилцооны хөтөлбөрт оролцсон АНУ-ын сурагчид, манай клубын боловсролын төслүүдэд оролцсон Монгол улсын УБ хотын болон хөдөө орон нутгийн хамтардаг сургуулийн төлөөлөл хүүхдүүд оролцов. Төсөлд оролцсон сурагчид өөрсдийн Ротаритай холбоотой туршлагаас хуваалцан, Монгол сурагчдын төлөөлөл маань морин хуураар мэндчилгээ дэвшүүлэв.



#1LOVE1PACKAGE – НЭГ ХҮН НЭГ ЭМЧИД



Улаанбаатар Пийс Авенью Ротари Клуб нь Ковид-19 цар тахлын эсрэг ачааны хүндийг нуруундаа үүрч, эрсдэлтэй орчинд ажиллаж байгаа эмч сувилагч нараас эерэг тохиолдол ихээр гарч байгаад санаа зовж байна. Цагаан нөмрөгт эмч, сувилагч, асрагч нарынхаа дархлааг дэмжих, мөн нийгэмд зөв үлгэр дуурайл үзүүлэх, олон нийтийг халдварын тархалтын эсрэг зөв арга хэмжээ авч, эрүүл мэнддээ анхаарахыг сурталчилан таниулах зорилгоор #1Love1Package – Нэг Хүн, Нэг Эмчид гэх нэртэй Чалленж төслийг санаачлан хэрэгжүүлж байна.

Төслийн хүрээнд 50,000 төг-ийн Дархлаа дэмжих Бэлгийн Багц гаргаж байгаа ба Үүнд:

- Витамин С
- Витамин D
- Анар жимсний Цэнэг жүүс
- Зөв аарц
- Аз жаргал бэлэглэх амтат шоколад

#1Love1Package – Нэг Хүн, Нэг Эмчид Чалленжид хэрхэн оролцох вэ?

1. Төсөл санаачлагч уг төсөл дээрээ боссон дүнгийн хэмжээгээр 50,000 төг-ийн Бэлгийн Багцуудаа аваад дурын Ковид-19 цар тахалтай тэмцэж байгаа улсын эмнэлгийн Эмч, Сувилагч нарт гардуулсан зургаа оруулж #1Love1Package – Нэг Хүн, Нэг Эмчид Чалленж-аа албан ёсоор зарлана.
2. #1Love1Package – Нэг Хүн, Нэг Эмчид Чалленж-аа зарлахдаа Ротари нийгэмлэгийн дурын 3-с дээш Ротари клуб, Ротаракт клуб, Интеракт клубуудыг сошиал хуудас болох Фэйсбук, Инстаграм, Твиттер г.м хуудсуудаараа зарлан дуудаж #Challenge-аа эхлүүлнэ.
3. Дуудагдсан клубууд #Challenge-д дуудагдсан өдрөөс эхлэн 14 хоногийн дотор клубын гишүүдээс Бэлгийн Багцын хандивуудаа босгоод өөрсдийн онцолсон Улсын эмнэлгийн эмч, сувилагч нартаа гардуулсан зургаа оруулж дараагийн 3 Ротари клубуудыг дуудна.
4. 50,000 төг-ийн Бэлгийн Багцад эмч нарт зориулж ямар бүтээгдэхүүн, эм, витамин байхыг Клубууд өөрсдөө дотоод зөвлөлөөрөө шийднэ.

Улаанбаатар Пийс Авенью Ротари Клубын гишүүдийн санхүүжилтээр Дархлаа дэмжих 50 – Бэлгийн Багцаа эхний ээлжинд Улсын Нэгдүгээр Төв Эмнэлэгийн цар тахалтай тэмцэх тэргүүн эгнээнд буюу улаан шугамд ажиллаж байгаа 50 эмч, сувилагч, асрагчдад гардуулж өгнө. #1Love1Package – Нэг Хүн, Нэг Эмчид Чалленжид Монголын нийт Ротари клубуудын гишүүдийг үүгээр дуудаж байна.

#1Love1Package - Нэг Хүн, Нэг Эмчид Чалленжид оролцох Ротари клубуудыг өөрсдийн сошиал Фэйсбук, Инстаграм, Twitter, Youtube хуудсаараа дамжуулан албан ёсоор дуудах ба Ковид-19-ийн цар тахалтай тэмцэж буй Эмч, сувилагч нараа баярлуулах аянд нэгдэж төслийн үр нөлөөг улам дэлгэрүүлнэ гэдэгт найдаж байна. Сайн үйлс улам их дэлгэрэх болтугай!



5. #1Love1Package – Нэг Хүн, Нэг Эмчид Чалленж нь цахим орчинд сошиал платформуудыг ашиглан хэрэгжих тул доорхи hashtag # ашиглан зарлахыг зөвлөж байна. Жич: Төсөл хэрэгжүүлэх клубууд төслөө хэрэгжүүлэх хугацаанд цаг ямагт Ковид19 цар тахлын аюулгүй байдал, эрүүл ахуй, зай барих, олуулаа цуглахгүй, алсаас, цахим байдлаар хэрэгжүүлэх тал дээр анхааран ажиллахыг зөвлөж байна.

#1Love1Package
#NegHunNegEmch
#GiveThanks
#EmchdeeBayarlalaa
#ByeCovid19
#StaySafeStayHealthy
#RotaryinAction
#ServeAboveSelf
#RCUBPA

МОНГОЛЫН РОТАРАКТ КЛУБУУД

ДЭЛХИЙН РОТАРАКТ 7 ХОНОГ

Бидний эх дэлхийн улс орон, өнцөг булан бүрийн төлөөлөл 18-аас дээш насны залуус хүмүүнлэгийн үйлсэд хүчин зүтгэж, нийгэмдээ үйлчлэн, манлайлал болон нийгмийн харилцааны ур чадвараа хөгжүүлэхээр нэгэн дээвэд дор цугалсан нь Ротаракт клубууд юм. Бид дэлхийн 180 оронд 10698 Ротаракт клуб, 203298 гишүүнтэй өнөр өтгөн гэр бүлийг бүрдүүлжээ. Хэдийгээр ковидтой холбоотой нөхцөл байдал сайнгүй байгаа ч гэсэн Ротарактууд маань эрч хүч, идэвхи сулралгүй, нөхцөл байдалтай төсөл хөтөлбөрүүдтэйгээ уялдуулан “Өөрөөсөө давж бусдад үйлчилсээр” байгаа нь гайхалтай юм.

Манай Монголын хувьд нийт 16 Ротаракт клуб байдаг бөгөөд өнгөрсөн улирлын хувьд доорх клубууд идэвхитэй үйл ажиллагаагаа явуулж байна. Бид энэ жил цомхоноор цахим орчин өөрсдийн нүүр зурагнуудаа Ротаракт хүрээтэй зургаар сольж олон нийтэд таниулах байдлаар тэмдэглэлээ.

ЗАЛУУЧУУДЫН ӨРГӨН ЧӨЛӨӨ РОТАРАКТ КЛУБ

2020-2021 онд хийгдсэн онцлох ажлууд

1. Багахангай дүүрэгт “Гудамжны номын сан” байршуулсан. Хойш хойшдоо энэхүү “Гудамжны номын сан” -г тогтмол давтамжтайгаар дүүргэж Монгол улсын 21 аймгийн алслагдсан сумдуудад хүрч ажиллаж мөн хүлээлгэн өгсөн номын сангийн хүмүүстэй холбогдож харилцаа холбоогоо сайжруулан Ротари Ротарактийн хүрээг тэлэх зорилттой ажиллаж байна.



2. Төслийн хорооноос Боловсрол сэдэв дор Online hackathon -ийг зохион байгуулж клубийн гишүүн тус бүрийн нийгэмд чиглэсэн төсөл хөтөлбөрүүдийг өрсөлдүүлж 2021 онд хэрэгжүүлэх төслийг сонгон шалгаруулсан. Уг цахим арга хэмжээнд Улаанбаатар ротари клуб болон mother клуб болох Ulaanbaatar Peace Avenue, DDR -аа мөн олон улсын байгууллага болон хувийн хэвшлийн нөлөө бүхий хүмүүсийг шүүгчээр оролцуулж нээлттэйгээр зохион байгуулсан. Улаанбаатар Ротари Клубээс 1 сая төгрөгийн урамшуулал авахаар болсон.



3. Дотоод хэргийн хороо карентины үеэр идэвхитэй ажилласан. Үүнд:

- Jotform дээр гишүүдийн нэгдсэн анкетийг бий болгож Digital шилжилтэнд бэлдэж байна.

Link: https://form.jotform.com/210462173387455?fbclid=IwAR16kfhBuVSOS_gF0SS13hoDPzLC7JigLoyARZKyvoZcTbLkrkUZWQa2ETy

- Клубын шинэ жилийн баярыг онлайнаар тэмдэглэсэн.
- Мартын 8, цэргийн баяр, бүх ротарактын өдрүүдийг нэгтгэн тэмдэглэж чадсан

4. Дотоод сургалтын хороо карентинийг боломж хэмээн олж харж 2 долоо хоног тутамд сургалт орсон. Үүнд:
- Илтгэх урлагын сургалт
 - Бясалгал буюу mindfulness гэж юу вэ? Түүний ач тус нь амьдралд хэрхэн нөлөөлөх вэ?
 - Хэрхэн бусдыг алмайруулсан PPT тавих вэ?
 - Театрт явахдаа хэрхэн биеэ авч явах вэ?
 - Зураач Gustav Klimt -н амьдрал уран бүтээл
 - Story telling буюу хэрхэн амжилттайгаар бичвэр бичих талаар сургалтууд орсон.

5. Гадаад хэргийн хороо “Myrotary.com хэрхэн хэрэглэх вэ?” гэсэн сэдвийн хүрээнд 2 удаа сургалт орж клубын бүх гишүүд мэдээлээс бөглөж бас MyRotary дээр тавигдсан сургалтуудыг дор бүрнээ үздэг болсон.

6. Залуучуудын өргөн чөлөө ротаракт клубийн зүгээс хөл хорио тогтоосон энэ цаг үед өөрсдийгөө хэрхэн хөгжүүлж байгаа талаар бусадтай хуваалцах #Knowledge_sharing_challenge -ийг зарлаж явуулсан. Уг сошиал компанит ажилд нийт манлайлагч 200 гаруй хүн нэгдсэн.




7. PR хорооныхон клубын FB page хуудсаа идэвхитэй хөтөлж #thankyou, #happybirthday постыг цаг тухайд нь оруулж байсан ба 2021 оны жилдээ цахим хуудастай болох зорилтыг тавинхичээж ажиллаж байна.



8. Бүх ротаракт нарын хамтарсан “Бяцхан баатрууд” төслийн ажлын хэсэгт идэвхитэй хамрагдан, хандив цуглуулах болон видео контент, постер бэлтгэн амжилттай оролцсон.



9-р Бүс:	10-р Бүс:
Улаанбаатар	Хүрээ
Монгол Улсын Их Сургууль	Туул
Цэцээ Гүн	Сэлбэ
Өргөө	Анагаах
Найрамдал	Цаст
Их Тэнгэр	Хобби
Залуучуудын Өргөн Чөлөө	



ЦЭЦЭЭ ГҮН РОТАРАКТ КЛУБ

2020 оны 10 сарын 21

“Цэцээ Гүн” Ротаракт клуб маань “Эрүүл мэндийн үйлчилгээг сайжруулах” төслийнхөө хүрээнд ХӨСҮТ-ийн насанд хүрэгчдийн цочмог гепатитийн тасагт 11 сая төгрөгөөр тохижуулсан “Түргэн тусламжийн өрөө”-г хүлээлгэж өглөө. Энэхүү төсөлд маань гүн туслалцаа үзүүлсэн Япон Улсын “Оозора” Ротари клуб, “Монгол дахь Ротари Ёнэяма төгсөгчдийн холбоо”, “Шинэ гэр түншлэл” ХХК, “ЛэндМН ББСБ” ХХК болон төсөлд маань хандив өргөсөн бүх хүмүүстээ баярлалаа. Төслийн маань үр дүнг олон мянган Монгол хүн хүртэж, эрүүл энх байгаасай!



2020 оны 10 сарын 26

“Цэцээ Гүн” Ротаракт клуб маань “Care Box” төслөө Баянзүрх дүүргийн зорилтод бүлгийн айлуудад дэмжлэг үзүүлэх зорилгоор “Баянзүрх дүүргийн эрүүл мэндийн төв” болон “Монголын оролцоо ба ялгаатай байдлыг дэмжих групп”-тэй хамтран амжилттай хэрэгжүүлээ. Бид төслийнхөө хүрээнд 100 орчим айлд дулаан хувцас, хүүхдүүдэд ном, тоглоом зэргийг хандивласан юм. Энэхүү төсөлд маань эд зүйлс хандивласан бүх хүмүүст болон биднийг дэмжиж ажилласан Баянзүрх дүүргийн эрүүл мэндийн төв, “Монголын оролцоо ба ялгаатай байдлыг дэмжих групп”-тэй баярлалаа. Та бүхний чин сэтгэлийн хандив хэрэгцээтэй хүмүүстээ очиж, өвлийг өнтэй давахад томоохон хувь нэмэр оруулж байгаа билээ.



2021 оны 1 сарын 22



“Цэцээ Гүн” Ротаракт клуб “Хүн бүр сурах эрхтэй” төслөө 2013 оноос эхлэн хэрэгжүүлж, 48 оюутанд 65 сая төгрөгийн сургалтын тэтгэлгийг өгсөн. Харин энэ жил бид “Ковид-19” өвчний дэгдэлтэй холбоотойгоор цахимаар 1-4 дүгээр курсийн 11 оюутныг гурван сарын хугацаатай менторшип хөтөлбөртөө хамрууллаа.

2021 оны 3 сарын 3

“Цэцээ Гүн” ротаракт клуб маань “Ковид-19” өвчний болзошгүй халдварын үед Өрхийн эрүүл мэндийн төвийг “Ковид-19” өвчинтэй тэмцэхэд нь туслах “Let's protect our protectors” төсөлдөө зургаан сая гаруй төгрөг босгож, СХД, БЗД, ХУД-н хамгийн алслагдмал байрлалтай дөрвөн өрхийн эмнэлэгт хувийн хамгаалах хэрэгслийн гурван сарын хэрэглээ, шаардлагатай төхөөрөмжүүдийг гардуулж өглөө. Эрүүл энхийн манаанд маань зогсож, хамгийн анхан бөгөөд амин чухал эрүүл мэндийн үйлчилгээг хоёргүй сэтгэл гарган үзүүлж буй эмч, сувилагч нартаа баярлалаа, та бүхний ажилд амжилт хүсье! Төсөлд маань маш том хувь нэмрийг оруулсан Ротари Олон улсын 3450 дүүргийн 9, 10-р бүсийн удирдлагууддаа дахин дахин баярласнаа илэрхийлмээр байна. Өдөр шөнөгүй хөдөлмөрлөж, энэхүү төслийг боловсруулж, хэрэгжүүлсэн хамт олондоо гүнээ талархлаа.



2021 оны 4 сарын 12

“Цэцээ Гүн” Ротаракт клуб болон Mongolian Young Mining Professionals хамтран Монгол Улсын ирээдүй болсон хүүхэд залуучуудын боловсролд хөрөнгө оруулах зорилгоор ЕБС-уудын номын санг тохижуулах төслийг эхлүүлж байна. Бид төслийнхөө хүрээнд сонгогдсон сургуулын номын санг ном, компьютер, тавилгаар хангаж боловсролын тэгш, хүртээмжтэй байдлыг дээшлүүлэх, цаашлаад сурагчдын хөгжилд чиглэсэн хөтөлбөрийг хэрэгжүүлэх юм.



УЛААНБААТАР ХАНГАРЬД РОТАРИ КЛУБ

2020-2021 оны Ерөнхийлөгч Ц.Ганхүү

“ЗӨӨЛӨН-1,2” ТӨСӨЛ

Улаанбаатар Хангарьд Ротари клуб нь Амгалан амаржих газрын амбулаторийн хүлээлгийн хэсгийн тохижилт, үйлчилгээний өнгө үзэмжийг сайжруулан, үйлчилгээний соёлыг дээшүүлэх, үйлчлүүлэгчийн тав тухтай орчинг бүрдүүлэх зорилготой “Зөөлөн-2” төслийг хэрэгжүүлж буй бөгөөд уг төсөл хэрэгжиснээр жирэмсэн эмэгтэйчүүдэд маань дараах давуу тал бий болох юм. Үүнд:

1. Жирэмсэн эмэгтэйчүүдэд зориулсан хүлээлгийн суудлыг илүү тав тухтай болгож буйданг байршуулах
2. Үйлчлүүлэгчдийн хүлээлгийг ил тод, тодорхой байлгах дугаарын дарааллын систем байрлуулах, жирэмсэн эхчүүд дарааллын дагуу соёлтой үйлчлүүлэх

Нийслэлийн хэмжээнд амаржих 3 газар /Өргөө, Амгалан, Хүрээ/ байдгаас Амгалан амаржих газар нийт 300 ортой, жилдээ 8000-9000 төрөлт хүлээн авдаг хотдоо 2-т ордог томоохон төрөх эмнэлэг юм байна.

Амбулатори дотор байрлах нөхөн үржихүй, дотор, эмэгтэйчүүд, эхо, жирэмсний хяналт, уламжлал, дуран, хавдар гэсэн тасгуудад нийт 10 хүлээлгийн дарааллын дэлгэц 15-16 ширхэг буйдан байршуулах юм.

Улаанбаатар Хангарьд Ротари клуб нь 2020 онд Өргөө амаржих газарт “Зөөлөн-1” төслийг амжилттай хэрэгжүүлж байсан түүхтэй.



ГЭРЭГЭ РОТАРИ КЛУБ

2020-2021 оны Ерөнхийлөгч Б.Номуунбилэгт

Хорио цээрийн дэглэмийн үеэр жижиг дунд бизнес эрхлэгчдийн бизнесийн орлого буурч, улсын хэмжээнд эдийн засгийн хямрал нүүрлэж ядуурал газар авах, иргэдийн сэтгэлзүйн хямрал, цаашлаад гэр бүлийн хүчирхийлэл эрчтэй нэмэгдэх сөрөг үр дагавруудаас сэргийлэх, хүчирхийллийн эсрэг нөлөөллийн ажилд хувь нэмрээ оруулах, хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдэд туслалцаа үзүүлэх, түүнчлэн жижиг дунд бизнес эрхлэгчдийг дэмжих зорилгоор Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Монгол Улс дахь Элчин сайдын яамны санаачилга, санхүүжилтээр Гэрэгэ Ротари клуб болон Улаанбаатар Централ Ротари олон улсын хүмүүнлэгийн байгууллагууд хамтран “COVID-19 цар тахлын үед гэр бүлийн хүчирхийллийн хохирогчдыг хамгаалах” төслийг хэрэгжүүлж дууслаа. Уг төслийн хүрээнд Улаанбаатар хотод байрлах хүчирхийллийн хохирогчдыг хамгаалах нэг цэгийн үйлчилгээний төвүүдэд 160 орчим анхан шатны ариун цэврийн болоод эмэгтэйчүүдийн хэрэглээний багц тараах, эрүүл мэндийн үзлэг шинжилгээ хийх зэрэг үйл ажиллагаа явуулсан. Ингэхдээ төсөлд шаардлагатай бараа материалуудыг дотоодын жижиг дунд үйлдвэрлэл, худалдаа эрхлэгчдээс авах замаар эдийн засгийн




тогтвортой байдлыг хангахад анхаарч, мөн байгальд ээлтэй органик, эко бүтээгдэхүүнийг сонгосон нь энэ төслийн нэгэн онцлог юм.



МОНГОЛЫН ИНТЕРАКТ КЛУБУУД


2021.02.21. Монголын Интеракт клуб, сургуулиудын анхны цахим уулзалт

Нийт 5 Интеракт клуб 6 сургуулийн төлөөлөл болох 90 гаруй хүүхэд багш нар оролцсон



2021.04.01. “Абсолют” сургуультай цахим уулзалт


- Оролцсон:
- Интеракт хариуцсан РР Н. Кема, РР Ариунгоо, Сэлбэ Ротари клубын ерөнхийлөгч О. Батгэрэл нар
 - Нийт 29 хүүхэд
- Ротари үндсэн зарчим, зорилго, Интерактын тухай үндсэн мэдээллийг өгсөн. Асуултанд хариу өгөх, зөвлөлөгөө өгөх хэлбэрээр зохион байгуулагдсан.



2021.04.03-04. 3450 Дүүргээс зохион байгуулсан “Peace Camp”

Name of Interact club	Name of sponsor Rotary club
IC of Hobby school	UB Rotary club
IC of Khuree Kosen	KHUREE Rotary club
IC of Shine Mongol school	
IC of Naran school	NARLAG Rotary club
IC of New Beginning school	
Potential IC of Absolut Elite school	SELBE Rotary club
Potential IC of 38th school	NIISLEI Rotary club

- Нийт оролцсон 23 хүүхэд:
- Монголын Интеракт клубээс 13
 - Интеракт клуб байгуулах сонирхолтой байгаа сургуулиудаас 10 хүүхэд
- УБ, Хүрээ, Нарлаг УБ Ротари клубууд, 3450 дүүрэг, Сэлбэ Ротари клубын ерөнхийлөгч О. Батгэрэл хувиасаа тус тус ивээн тэтгэсэн хурал болсон.



2021.04.07. “Монгол Билиг Оюун” сургуультай цахим уулзалт

- 76 хүүхэд 25 багш оролцсон
- Интеракт хариуцсан РР Н. Кема, РР Ариунгоо нар цахимаар Ротари үндсэн зарчим, зорилго, Интерактын тухай үндсэн мэдээллийг өгсөн. Асуултанд хариу өгөх, зөвлөлөгөө өгөх хэлбэрээр зохион байгуулагдсан.



2021.04.11. Монголын Интеракт клуб, сургуулиудын ээлжит цахим уулзалт

- Нийт 96 хүн оролцсон
 - “Peace Camp”-д оролцсон хүүхдүүд туршлага, сурсан зүйлээсээ хуваалцсан
- Интеракт клуб байгуулах сонирхолтой “Монгол Билиг Оюун” мөн “Сэлбэ” сургууль нар “Ротари ээж” клубтэй болох сонирхолоо илэрхийлсэн юм.



2021.05.22-НД 3450 ДҮҮРГИЙН “INTERACT CONFERENCE” БОЛНО

Монголоос Хобби Интерактаас РЕ Мөнх-Ужин, Шинэ Эхлэл интерактаас Р Уяанга нар зохион байгуулах ажлын хэсэгт оролцож байгаа.

ХҮРЭЭ РОТАРИ КЛУБЭЭС ЗОХИОН БАЙГУУЛСАН “ИНТЕРАКТ БА МИНИЙ БОЛОМЖ” ЗОХИОН БИЧЛЭГИЙН УРАЛДААН ШАЛГАРСАН 2 ОРОЛЦОГЧИЙН ЗОХИОН БИЧЛЭГ

Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэж байна. Намайг Мөнхсайханы Зоригт гэдэг. Хүрээ Коосэн Интеракт клубын 2020-2021 оны тэргүүнээр ажиллаж байна.

Шинэ Монгол Технологийн Коллежийн цахилгаан электроникийн 4-р курст суралцдаг. Анх 15 настай байхдаа шинэ сургуульд ороод миний амьдрал шинээр л эхлэх шиг болсон. Шинэ сургууль, шинэ орчин, шинэ багш найзууд гээд л миний амьдралын мартагдахааргүй үе байсан. Тэр үед Интеракт клубын талаар сонсоод сонирхолыг минь их татсан. Өмнө нь гар бөмбөгийн дугуйлангаас өөр зүйлд явдаггүй би илүү нээлттэй дотоод хүн маань задарч эхэлсэн. Содон нэртэй сайн дурын клубт найзуудтайгаа хамт элсэж орж интерактын гэр бүлийн нэгэн гишүүн болсон юм. Энэ айл өрхийн нэгэн гишүүн болсон нь миний хувьд маш нэр хүндийн хэрэг байсан.

Дөнгөж шинээр байгуулагдаж байсан болохоор бүх гишүүд л шинээрээ байсан. Клубын маань ерөнхийлөгч их нээлттэй бодож санасанаа шууд л илэрхийлдэг сэнпай маань байсан. Би интеракт клубын гишүүн болсоноос хойш аль хэдийн 4 дэх жил рүү орсон байна. Хэдийгээр манай клуб тасралтгүй үйл ажиллагаа явуулдаггүй байсан ч би дотроо их бодлыг бодож явсаар ирсэн нь одоогийн минь өндөрлөгт авчирсан байх. Би нэг зүйлдээ тууштай байхыг илүүд үздэг. 6-р ангисаа хойш одоог хүртэл волейболын спортоор хичээллэж 1-р зэрэгтэй болж чадсан. Өөр надад бас нэг хобби байдаг. Би хүнд туслах хар багийн л хобби той байсан. Энэ хоббиндоо хөтлөгдөн магадгүй энэ клубт анх орсон байх. Би интеракт болсоноороо өөртөө болон өөр олон хүнд их бага хэмжээний өөрчлөлтийг хийж чадсан гэж бодож байна. Мөн манай сургууль Япон хэв маягийн сургууль учраас япон хүмүүжил соёл манай сургуулийн үзэл санаа зэрэг нь олон өөр сургуулийн хүүхдүүдэд маш том соёл болдог. Түүнээс дурдвал улсын сургууль 1,2 насны зөрүүг тоохгүй байдаг. Гэтэл Шинэ монгол гэх тогоон дотор сэнпай коухай бол маш чухал байдаг. Энэ мэт маш олон соёлыг түгээсэн байдаг.

Би интеракт клубын ерөнхийлөгч болоод яг нэг жил болох гэж байна. 1 сард өмнөх ерөнхийлөгч маань төгсөх гээд надад үүрэгт ажиллаа шилжүүлэн өгөх үед манай клуб 3 хан гишүүнтэй байсан юм. Тэгээд асар том төлөвлөгөө гарган ажиллах гэсэн боловч аюулт цар тахалтай нүүр тулгарсан юм. Тэгсэн ч би 3 н гишүүнийхээ хамт гадуур маск үнэгүй тараасан юм. Бид сайн дурын клуб юмаа таньд үнэгүй маск өгж байгаа юмаа гэхэд хүмүүс их баярласан байсан. Бид хотын төвөөр маскгүй иргэдэд маск тараасан. Мөн 7-р сард болох эрх шилжүүлэх ёслолд манай клубын гишүүдийн нас нь бүгд гүйцсэн байсан учраас Ж.Галбадрах захиралд уламжлан энэ жил сунгах талаар лавлаж сунгагдсан. Энэ нь надад ирсэн өөрийгөө болон бусдыг хөгжүүлэх хамгийн том боломж минь болсон. Хичээлийн шинэ жил эхлэх үеэр клубын үйл ажиллагаагаа сэргээн дахин нэг том сэргэлт хийсэн. Клубээ танилцуулж ангиудаар яваад бүртгэл явагдахад 60 гаруй хүүхэд бүртгүүлэхэд өөрөө гайхаж билээ.

Одоо манай клуб 28 хүний бүрэлдэхүүнтэй хөл хорионы үед ч гэсэн үйл ажиллагаагаа явуулсаар байна. Аж үйлдвэрийн 4-р хувьсгалын үед цахим орчин, social media, social platform асар хурдтай хөгжиж буй энэ үед манай бүх үйл ажиллагаа цахим хэлбэрээр явж байна. 7 хоног бүр хувь хүнд хэрэгтэй сэдвүүдээр мэргэжил сонголт, шинжлэх ухаан, өсвөр насны үерхэл гэх мэт бидний насныханд зориулсан контент маань маш амжилттай болж байна. Мөн япон үг цээжилүүлэх, сонирхолтой олон төрлийн баримт, тоглоом зэргээр цахим хэлбэрээр ажиллаж байгаад маш их баярлаж байна. Дан ганц хүмүүнлэгийн ажил бус хувь хүнд төвлөрсөн, хүмүүжилд нь тус дэм болох үүднээс сайн дурын ажил хийж байгаагаараа клубынхаа дүү нараар их бахархаж байна.

Интеракт клубт байсан 3 жилийн хугацаанд миний бодсон зүйл бол цаашид Монгол улсад энэ Интеракт клубыг маш их өргөн

хүрээтэй болговол олон хүүхдэд тус дэм болж болох санагдсан. Учир нь юу вэ гэвэл одоогийн байдлаар албан ёсны 4 интеракт клуб л үйл ажиллагаагаа явуулж байна. Энэ тал дээр манай Ротари, ротаракт клубын ах эгч нар маань төсөл боловсруулан дүүрэг аймаг бүрт нэг нэг клуб байгуулах ч юм уу энэ интерактийг илүү өргөн хүрээтэй болговол монголын хүүхэд залууст маш том дэвшил ирж болохоор санагдаж байна. Сургууль бүрт ийм интеракт клуб байвал сурагчдын нийгмийн идэвх оролцоо нэмэгдэж хүүхдүүд илүү нээлттэй болж цаашлаад ажлын байранд гарах үед багаар ажиллах чадвар нь нэмэгднэ гэж би бодож байна.

Би цаашдаа дэвшин ротаракт клубын гишүүн болохоор шийдсэн. Ротари бол миний амьдралын салшгүй нэгэн зүйл болсон учираас. Яагаад гэвэл ротаричуудын хийсэн ажил, төсөл хоорондын харилцаа эв нэгдэл гээд бүх зүйлс нь бахархмаар. Би ч гэсэн ийм бахархалтай хүнд чин сэтгэлээсээ тусалладаг үлгэр жишээ ротари болохын төлөө хичээн суралцах зорилготой байна. Маш олон жилийн түүхтэй энэхүү байгууллага 25 жилийн өмнө Монгол улсад маань нэвтэрч Монголд маш олон Ротари клуб байгуулагдаж өөр өөрийн маш олон төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаа нь энэ нийгэмд маш их тус болж байна гэж би боддог.

Интеракт клубын надад мэдрэгдсэн хамгийн том давуу тал бол багаар ажиллах чадвар суудаг. Нэг баг болж төсөл боловсруулж хэрэгжүүлж төрнийхээ төлөө хэдүүлээ гоё ажиллаж тэндээс их урам авдаг нь маш сайхан мэдрэмжийг төрүүлдэг. Анх 2018 онд анхны том төсөл хандивын ажилд орж байхад их зүйлийг сурч мэдэж байлаа. 1 настай элэгний цирозтой хүүхдэд бид нар хандивын хайрцагаар чадахаараа хандив цуглуулж байсан. Харамсалтай нь тэр хүүхэд маань бурхны оронд заларсан. Бид цуглуулсан нийт хандиваа ар гэрт нь хандивлаад дотроо уйлж байсан. Тухайн үед маш гоё багаар ажиллаж мөнгөө шилэн дансанд байлгаж бүгд мэрийлттэй байхыг харах аз жаргалтай мэдрэмж байсан. Бас бидний клубын уламжлалт ажил байдаг. Өдөржин л бидний сурах орчны ариун цэвэр, аюулгүй, цэвэрхэн байдлыг үргэлж сахиж байдаг цэвэрлэгч нартаа туслах өдөр буюу “Талархалын өдөр” гэж зохион байгуулдаг. Энэ өдрөөр сургуулийнхаа кордиор, ариун цэврийн өрөө, зоогийн газар гэх мэт газрыг цэвэрлэж нэг өдөр тус болдог. Мөн 2 удаа өвлийн хүйтэнд ажиллаж байгаа цэвэрлэх газрын ажилчид(ТҮК) халуун цай аарц өгч ажилд нь туслаж байсан нь энэ бидэнд маш том ажлын сургамж, туршлага мөн тэдний сайхан сэтгэлийг хүлээн авсан юм.

Бусдад тусална гэдэг хүнээс гарах хамгийн сайхан зүйл гэж би боддог. Хүнд хариу нэхэлгүй тус хүргэх нь өөрөө асар их хүндэтгэл, хайр энэрэл, бахархал зэргийг бага зэргээр авдаг. Энэ нь тусалсан хүнд урам болдог. Манай клубын гол зорилго уриа бол “Бид нийгэмд эерэг хандлагыг төрүүлнэ” юм. Бид зөвхөн сайн дурын клубээс гадна үе тэнгийнхэндээ болон энэ өнөөгийн монголын нийгэмд үлгэр дууриалал үзүүлэн, эерэг байдлыг түгээх зорилготойгоор ажиллаж байна. Цаашлаад манай клубын үйл ажиллагаа улам өргөжиж илүү их зүйлийг хийхээр төлөвлөсөн байгаа. Интеракт клуб маань ирээдүйд илүү олон хүнтэй болоод илүү их зүйлийг хийнэ гэдэгт миний бие итгэлтэй байна.

Хүрээ коосэн интеракт клуб

Ерөнхийлөгч: М.Зоригт

Улаанбаатар хот 2020.01.20

Олон хувилбар дундаас сонгосон миний сонголт бол ИНТЕРАКТ КЛУБ. Уг клуб нь өөрийгөө олон талаасаа таньж мэдэх, гүнзгийрүүлэн хөгжүүлэх, нийгмийн оролцоогоо идэвхжүүлэх, хамтран ажиллах чадварыг сайжруулах гээд амьдралд чухал зүйлсийг олгодог тул сонгосон.

Өсвөр үеийнхэн сайн дурын ажил хийх, бусдад туслах, нийгэмд тустай зүйл хийх хүсэлтэй байдаг ч ихэнх сайн дурын байгууллагууд насанд хүрсэн байх шаардлагатай тавьдаг. Саяхныг хүртэл зарим хүүхдүүдтэй адил хаана, аль багт орохоо мэдэхгүй явж байлаа. Харин надад шинэ боломж гарч ирсэн нь интеракт клуб маань юм. Клубынхаа танилцуулгыг сонсоод л шууд нэгдэхээр шийдсэн. Өсвөрийнхнийг нийгэмд эзлэх байр суурийг өргөжүүлж, тэдний үйл ажиллагаа хийх боломжийг олгодог учир миний хайж буй клуб байсан.

Мөн миний хувьд хамгийн чухал эзэмших чадвар бол багаар хамтарч ажиллах. Багаар хамтран ажилласнаар амьдралд цаашдаа хэрэг болох олон зан чанар, ухаарал, туршлагыг суулгана. “Нэг нь нийтийн төлөө, нийт нь нэгнийхээ төлөө” Хамт олон гэдэг хамгийн чухал байдаг. Олон хүмүүстэй танилцаж, нөхөрлөж, тэднээс суралцаад л явна. Хүмүүстэй харилцаж сурна гэдэг үнэхээр чухал дэвшилт юм. Бусдын туршлагыг сонсож, хийж байгаа, хийх гэж буй зүйлс гэх мэт өөрт тохиож байгаагүй зүйлсийг сонсож, судалж, тархиндаа дүгнэлт хийх нь надиx таалагддаг. Мэдээж хүсэл мөрөөдлөөр дүүрэн гишүүдтэй клубээсээ суралцах зүйл их.

Нийгэмд тулгамдаж буй асуудлыг хайж олох, тусламж хэрэгтэй хүнийг олж туслах гэх мэт үйл ажиллагаануудад судалгаа хийх, бэлдэх үе хамгийн чухал байдаг. Хүмүүсийг уриалан дуудаж оролцуулахын тулд шинэ санаа гарган бэлтгэж, үйл ажиллагааг явуулахын тулд дан ганц өөрийн санаа бодол бус багийн гишүүдийн санаан дээр анализ хийж, хамгийн боловсронгуй шийдэл гаргах хэрэгтэй. Бусдын санааг нийлүүлж гайхалтай санаа гаргаж ирэх нь бас л нэгэн чадвар. Гаргасан санаан дээрээ мэдээлэл цуглуулж, найруулан мэдээлэл бэлтгэх нь мөн өөрийгөө хөгжүүлж байгаа боломж.

Мэдээж бусдыг буруу биш зөв зүйлд уриалан дуудна. Бусдыг уриалан дуудна, дайчилна гэдэг маш том хариуцлага. Нийгэмд хамгийн зөв гэсэн үйл ажиллагаа хийдэг. Маш их зоригтой, итгэл тээсэн мундаг хүүхдүүдийн нэгдэл гэж би ойлгодог.

Клубийнхаа үйл ажиллагаанд оролцох нь үнэхээр сайхан. Эрч хүчээр цэнэглэгдсэн найзуудтай нийгэмд сайн сайхныг түгээх нь бидний ажил шүү дээ. Цагийг үр бүтээлтэй бас хөгжилтэй өнгөрөөнө. Эргээд бодоход ч дурсамжтай. Хийсэн үйл ажиллагаанууд маань зорилгодоо хүрэх хамгийн бахархалтай байдаг. Зарим үед бүтэлгүйтэж болно. Гэхдээ бүтэлгүйтлийг муугаар харах биш амжилтанд хүрэх туршлага гэж хараад илүү сайжруулаад ахин эхэлдэг. Үйл ажиллагаанд оролцоход танилын хүрээгээ тэлж, олон найз нөхөдтэй болдог.

Хөл хорионы үед бүх үйл ажиллагаа маань цахим хэлбэрээр явагдаж байгаа нь бас л бидний өөрийгөө хөгжүүлэх боломж гэж харж байна. Цахимаар мэдээлэл хүргэх, контент хийх үед бид нар энгийн үеэсээ илүү техник технологийг ашиглаж байгаа. Ажилаа хийх үед мэдэхгүй зүйл гарч ирэх үед бид сошиалаас бүгдийг суран хийж байна. Энэ нь шинэ зүйл туршиж, сурч мэдэхээс гадна бие даан судлах, суралцах чадварыг илүү сайжруулж байгаа. Ингээд харахаар хөл хорио ч бас зөв өнгөрөөвөл тийм ч муу биш. Ямар ч үед хөгжиж байх нь миний боломж. Цаашлаад биднийг цахимаар бусдад сайнаар нөлөөлөх том гүүрийн эхлэл болж өгч байна. Орчин үед сошиал орчинд хүмүүс сайн сайхныг түгээх, хүрээгээ тэлж байгаа.

Мөн клубээрээ эсвэл клубээ төлөөлөн уралдаан тэмцээнд оролцох нь өрсөлдөх чадвараа нэмэгдүүлэх миний боломж юм. Баг хамт олныхоо итгэлийг тээж байгаа нь бас хариуцлага болдог. Энэ бүхнээс суралцаж байдаг.

Энэ бүхний ард бие биенээ хүндэтгэх, нэгнийгээ ойлгох, тусалж дэмжих

гээд багаас гадна бус баг дотроо ч хийх зүйлс олон. Тэгэхээр манай клуб бол дотроосоо ч гаднаасаа ч суралцах чадвар ихтэй байдаг. Энэ л миний байх ёстой газар, хийх ёстой газар, учрах ёстой хүмүүс, атгах ёстой боломж.

Үйл ажиллагаа гэдэг нь өөрөө маш олон чадвараар бүтдэг зүйл. Тиймээс бид ганцаараа бус багаараа ажилладаг. Ганцаараа амжиланд хүрсэн хүн гэж байдаггүй. Түүнд тусалсан хүмүүс байдаг. Тиймээс манай клуб бол миний боломж, бидний боломж, миний амжилт, бидний амжилт.

Хийсэн үйл ажиллагаанууд маань биднийг сурталчилж, клубыг илүү өргөтгөх, цаашдаа илүү өргөн цар хүрээтэй төсөл хийх боломжийг олгодог. Нийгэмд илүү танигдаж бидэн шиг хүсэл мөрөөдөлтэй өсвөр үеийнхнийг нэгтгэж том баг болгон ажиллах нь миний зорилго. Залуу үеийг зөв үзэл бодолтой, зөв ёс суртахуунтай болгохын тулд өөрсдөдөө нэгтгэж нэг баг болгох. Интерактыг мэдэхгүй хүүхдүүдэд таниулах хэрэгтэй.

Ирээдүйн том хүрээтэй интеракт клубын эхлэл нь би, бид. Тухайн цаг үеийн асуудлыг өөрсдийн боломж болгон ашиглаж, бусдад туслах хэрэгтэй. Жишээ нь, одоо тулгамдаж байгаа асуудал бол КОРОНА (Covid 19) вирустай холбоотой хөл хорио тогтоогоод байна. Хөл хорионд сурагчид теле болон цахим хичээл үзэж судалж байгаа. Дэлгэцийн ардаас хичээлээ ойлгох нь хэцүү байна гэж сурагчид ярьцгааж байна. Үүнийг бид асуудал болгон авч хичээлтэй холбоотой цахим контент хийж үеийн нөхдөдөө туслах, хэрхэн биеэ дааж сурах, мэдээлэл хайх зэрэг суралцахад хэрэгтэй мэдээллүүдийг бэлтгэн түгээх хэрэгтэй. Хөл хорионд хоол ундгүй байгаа ядуу өрхүүдэд тусламж үзүүлэх гэх мэтчилэн хүн болгоны мэдэж байгаа ч хүрч ажиллаж чадахгүй байгаа тэдгээр зүйлсд хөрөнгө оруулалт хийх.

Таны хэрэг бүтвэл миний хэрэг бүтнэ. Тийм учир сайхан сэтгэлээр хүнд туслах шиг сайхан зүйл үгүй. Хүнд туслах нь өөрийгөө эерэг энергиэр хүрээлүүлдэг. Ийм мэдрэмжийг мэдрэх нь хэн хүнд сайхан.

Хүнд маш олон талаар тусалж болно. Хоол ундгүй хүнд хүнс бэлдэж өгөх, өвчтэй хүнд эмчилгээний төлбөрт нь нэмэр болох, өнчин хүүхдүүдэд сэтгэлийн дэм өгөх, ахмад настангуудад туслах, хичээлээ ойлгохгүй байгаа сурагчдад хичээлийг нь зааж өгөх, хэн нэгний сонирхол, мөрөөдөлд нь хөрөнгө оруулах гэх мэт. Гол нь тусламж хэрэгтэй хэн бүхэнд хүрч ажиллах хамт олон бүрдүүлэх чухал. Сайн хүмүүстэй хамт ажиллах нь илүү өсөн дэвжих талтай. Миний мөрөөдөл биелэж, интеракт маань хүрээгээ тэлэн олон улстай харилцах түвшнийх болох үед бидэнд илүү том боломж нээгдэнэ. Монголчууддаа олон сайхан соёлыг түгээж ажиллавал сайхан. Тэгснээр ирээдүй болсон өсвөр үеийнхэн маань илүү мэдлэгтэй, хөгжингүй болно гэж бодож байна.

Үүний тулд одоо байгаа интерактүүд маань нэгдэж ажиллаж байна. Хүн бүр хичээвэл боломжгүй зүйл гэж үгүй шүү дээ. Бусдын дотор гайхалтай санаа маш их байгаа. Тэрийгээ өөрөө ч мэдэхгүй явж байдаг. Үүнийгээ олж илрүүлэн хэрэгжүүлэхийн тулд манай клуб маань том дэмжлэг болдог гэж боддог.

Хаанаас, юунаас эхлэхээ мэдэхгүй байгаа олон хүүхэд залуучуудад ирээдүйдээ зөв бөгөөд бодитой хөрөнгө оруулалт хийхийг сурталчилмаар байна. Би ч бас юу ч мэдэхгүй энэ клубт орж ирээд, олон зүйлсийг сурсаар...

Миний хувьд амжилтийн карьераа эхлүүлэх боломж бол интеракт клуб. Хувь хүний хөгжил, нийгмийн байр суурь талаас олон чадварыг суулгаж өгдөг цэг бол интеракт клуб. Бүх зүйлээс нь суралцаж байдаг болохоор миний хамгийн том давуу тал.

ХҮРЭЭ ИНТЕРАКТ клубын гишүүн, ШМТК-ийн 1-4 ангийн оюутан

Ба.Хүслэн

РОТАРИГ ОЛОН НИЙТЭД ТАНИУЛАХ ХОРОО: МЭДЭЭЛЭЛ АВАХ СУВГУУД

1. ОЛОН УЛСЫН ХҮРЭЭНД:

MyRotary <https://my.rotary.org/en>

Rotary International Facebook хуудас: <https://www.facebook.com/rotary>

2. ДҮҮРГИЙН ХҮРЭЭНД

Дүүргийн вэбсайт: <https://rotary3450.org/>

Rotary International District 3450 Facebook хуудас: <https://www.facebook.com/Rotary3450>

DG Онлайн сонин: <http://dg-newsletter.rid3450.org/>

Сар бүрийн 5-ний дотор өмнөх сарын мэдээ мэдээллийг зураг болон видеогоор salimabolor@gmail.com хаяг руу илгээх

3. БҮСИЙН ХҮРЭЭНД

Бүх гишүүдийн ГРУПП /хаалттай/ Mongolian Rotary Clubs Members: <https://www.facebook.com/groups/539691572738697>

Олон нийтийн PAGE /нээлттэй/ Mongolian Rotary Clubs: <https://www.facebook.com/RotaryMongolia>

Бүсийн вэбсайт: <http://rotarymongolia.org/>

Youtube channel: Rotary Mongolia

Бүсийн сонин мэдээ мэдээлэл хуваалцах суваг

Олон Улсын Ротарийн 3450 Дүүргийн Олон Нийтэд Таниулах Хорооны дэд дарга,
DAG Б.Сальма



ӨӨРӨӨСӨӨ ДАВЖ БУСДАД ҮЙЛЧЛЭХ SERVE ABOVE SELF

1905 ОНД АНУ-ЫН ЧИКАГО ХОТОД БАЙГУУЛАГДСАН



ДЭЛХИЙ ДАЯАР НИЙТ 36,000 ГАРУЙ КЛУБ



НИЙТ 165 ОРОНД



1,2 САЯ ГИШҮҮД



МОНГОЛ УЛСАД НИЙТ 18 РОТАРИ КЛУБ (30 ДЭЭШ НАСНЫ), 15 РОТАРАКТ КЛУБ (18-30 НАС), 4 ИНТЕРАКТ (12-18 НАС) КЛУБУУД 500 ГАРУЙ ГИШҮҮДТЭЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БАЙНА.

РОТАРИД НЭГДЭХ ШАЛТГААНУУД:

- НӨХӨРЛӨЛ
- ХУВИЙН ӨСӨЛТ, ХӨГЖИЛ
- НИЙГМИЙН ГИШҮҮН БАЙХ
- БАЯР ХӨӨР
- ДЭЛХИЙН ИРГЭН
- ГЭР БҮЛИЙН ХӨТӨЛБӨРҮҮД
- НЭР ХҮНД
- БИЗНЕСИЙН ХӨГЖИЛ

РОТАРИ МЭДЭЭЛЛИЙН ТӨВ:

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Юнион Бюлдинг А блок, 13 давхар, 1305 тоот.
Утас: (+976) 7700-0592, 99059960 Имэйл: mongoliarotary@gmail.com